



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА
А.ХҮРЭЛШАГАЙ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-3-25 № 05/36 УАГ-САГ/2013/22/СТА-773

Г Эд хөрөнгийн тооллого хийх тухай Г

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төв аппарат үндсэн хөрөнгө 957.8 сая, эргэлтийн хөрөнгө 381.3 сая төгрөг, нийт 1,339.2 сая төгрөгийн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хариуцана... мөн 11.2-д эд хөрөнгийн тооллогыг дараахь тохиолдолд заавал хийнэ... 11.2.1-д жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө... гэж заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж байх, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч дээрх зөрчлийг арилгах албан шаардлага өгч байна.


Дээрхи зөрчлийг арилгаж цаашид гаргахгүй байхын тулд ажлаа зохион байгуулж, биелэлтийг 2013 оны 1 дүгээр улиралд багтаан тооллого хийж, тооцоо бодон Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга А.Хүрэлшагай, санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Л.Лувсан нарт даалгав.



Бичсэн:
Санхүүгийн аудитын газрын
Аудитор Ш.Отгонбаяр

УХА0122

АЛБАН ШААРДЛАГА:



Газрын харилцаа, геодези,
зураг зүйн газрын дарга
А.Хүрэлшагай
Ерөнхий нягтлан бодогч
Л.Лувсан

070105